

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 15-ний өдөр

Дугаар 02/23

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8.В-ийн 8.13 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Монноос” хувьцаат компани нь 2022 онд компанийн үйл ажиллагаа явуулаагүй, 2022 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй гэсэн гаргасан шийдвэрийн эдийн засгийн болон хуулийн үндэслэлийг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч П.Оюунбаярт даалгасугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН



П.ОЮУНБАЯР

С.АЛИМАА

Ц.ЦЭНГЭЛБАЯР

С.МӨНХЖАРГАЛ

П.ОЮУНБАЯР

Х.ЭРДЭНЭБАЯР

Х.ОЮУНГЭРЭЛ

Л.БҮРЭНТЭГШ

И.СЭР-ОД